

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Агуулга**

1.	Аудитын гэрчилгээ .....	2
2.	Аудитын тайлан.....	4
1.1	Оршил.....	4
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
1.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
1.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
1.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
1.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
1.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
1.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
1.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
1.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
1.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
1.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
1.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудитлагдсан санхүүгийн тайлан.....	11
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/229  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН  
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig\_KhereglYawsan\_Bichig\2019\0224SAG18.Docx


070511

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цагааннуур чөлөөт бүсийн захирагч А.Аманкелди танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2019 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор О.Цэндхүү чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудиторын туслах Т.Алтанчимэг, Д.Эрдэнэбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цагааннуур чөлөөт бүсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Цагааннуур чөлөөт бүс нь олон улсын түвшинд хүрсэн жишиг чөлөөт бүсийг байгуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын өсөлтийг тэргүүлэгч, эрчимтэй хөгжлийн төв болгон, баруун бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Цагааннуур чөлөөт бүсийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь гадаад худалдаа гэж холбогдох хууль болон улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан боловч энэ чиглэлээр тодорхой ажлууд хийгдээгүй байна.

Цагааннуур чөлөөт бүсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Цагааннуур чөлөөт бүсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Чөлөөт бүсийн тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Газрын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цагааннуур чөлөөт бүсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цагааннуур чөлөөт бүсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Цагааннуур чөлөөт бүсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Цагааннуур чөлөөт бүсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 19 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус чөлөөт бүс нь төрийн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага тул нийт зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 369,535.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 7,390.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь чөлөөт бүсийн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, эрсдэл бага байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 23 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 16 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	11,030.0	



2	Албан шаардлага өгсөн	3	1,156.0
	Дүн	4	12,186.0

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 85,372.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 73,186.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,156.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага 11,030.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант оны эцэст 2 харилцагчтай холбоотой 2016 онд үүссэн 1,156.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

2. Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 833.1 м2 газрыг 1,666.2 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан байна. Гэтэл Баян-Өлгийн аймгийн засаг даргын 2014 оны 02 дугаар захирамж болон газрын кадастрын зургаар 883.1 м2 талбайг эзэмшүүлэхээр шийдвэр гарсан нь “Иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

3. Тус чөлөөт бүс нь 2006 онд үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаа явуулахаар 2008 онд 1,082,967.2 мянган төгрөгийн хашаа барьж хөрөнгө оруулалт хийсэн. 2015 оноос 2018 он хүртэлх 4 жилийн хугацаанд 1,031,620.0 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаандаа зарцуулж байгаа боловч үйл ажиллагаагаа одоог хүртэл эхлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

## **2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад дараах асуудлыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарал хандууна. Үүнд:

- 1.9.1. Иргэд, аж ахуйн нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулсан эсэх, хуулийн этгээдийн гэрээнд газрын төлбөр төлөхөөр заасан эсэх, үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд төлбөр төлөхгүй байх үндэслэлтэй эсэх;
- 1.9.2. Чөлөөт бүс нь 2006 онд үүсгэн байгуулагдаж 2008 онд 1,082,967.2 мянган төгрөгийн хашаа барьж хөрөнгө оруулалт хийсэн боловч одоог хүртэл үйл ажиллагаагаа эхлүүлээгүй;
- 1.9.3. Тайлант онд 6,779.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн боловч төсвийн төлөвлөгөөнд тусгаагүй.

## **2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цагааннуур чөлөөт бүсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой таван бүлэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 304,407.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт 311,186.3 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого төвлөрүүлж, 300,969.4 мянган төгрөгийн зарцуулалт гаргаж, 10,216.9 мянган төгрөгийг жилийн эцэст буцаан төвлөрүүлсэн.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Цагааннуур чөлөөт бүс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулахад нийт 3 ангилал бүхий 20 төрлийн 124 мэдээлэл оруулахаас 124 мэдээллийг иж бүрэн байршуулсан. Мөнгөн хөрөнгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад 6 удаагийн гүйлгээгээр 141,556.6 мянган төгрөгийн орлогын, 1 удаагийн гүйлгээгээр 24,238.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ байршуулж 2018 оны 07 сараас хойшхи 6 удаагийн 162,850.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг байршуулаагүй байна.

## **2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цагааннуур чөлөөт бүсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд нийт 5 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан 11,030.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон. Тус чөлөөт бүс нь 27 орон тоотой ажиллахаар батлуулсан боловч гүйцэтгэлээр 20 орон тоотой ажиллаж, үйл ажиллагаа явуулаагүй тул ажлын ачаалал бага байхад гэрээт ажилтанд ажлын хөлс олгосон нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

##### **1.2 Эрсдэл**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

##### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын үйл ажиллагаа хэвийн жигд явагдаагүй, батлагдсан орон тоогоор ажиллаж байгаа ажиллагсдын ажлын ачаалал бага байхад ажлаа зөв хуваарилан ажиллуулах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

##### **1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,526,216.97</u></b>	<b><u>6,818,934.48</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	24,941.00	14,940.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	24,941.00	14,940.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	24,941.00	14,940.00
31213	Арилжааны банк дахь харилцах	24,941.00	14,940.00
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,441,828.40	1,749,648.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	157,413.46	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,284,414.94	1,749,648.74
3351	Байгууллагаас авах авлага	54,882.65	320,116.45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,229,532.29	1,429,532.29
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,377,556.57	617,232.57
34600	Урьдчилж гарсан зардал	1,377,556.57	617,232.57
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,681,891.00	4,437,113.17
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	311,650.00	256,200.00
35110	Тусгай зориулалттай материал	311,650.00	256,200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,370,241.00	4,180,913.17
35410	Бичиг хэргийн материал	1,432,322.00	1,517,665.17
35470	Бусад хангамжийн материал	3,937,919.00	2,663,248.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>896,646,508.31</u></b>	<b><u>873,425,751.46</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	896,646,508.31	873,425,751.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	896,440,258.34	867,716,301.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,205,910,941.00	834,893,774.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-358,354,349.17	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,791,080.09	-38,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,842,679.00	59,534,616.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,943,567.78	-30,891,555.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,598,295.82	5,963,772.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,064,660.44	-2,026,307.39
39217	Ном	242,000.00	242,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	206,249.97	5,709,450.01
39301	Програм хангамж	1,200,000.00	4,210,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-993,750.03	-266,749.99
39303	Бусад биет бус хөрөнгө	187,000,000.00	1,766,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-187,000,000.00	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>907,172,725.28</u></b>	<b><u>880,244,685.94</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,261,190.00</u></b>	<b><u>1,156,001.53</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,261,190.00	1,156,001.53
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,261,190.00	1,156,001.53

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,261,190.00	1,156,001.53
41361	Байгууллагад төлөх өглөг	2,261,190.00	1,156,000.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>904,911,535.28</u></b>	<b><u>879,088,684.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	904,911,535.28	879,088,684.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,863,483.00	72,629,683.00
51101	Өмч: - төрийн	70,863,483.00	72,629,683.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	833,161,139.69	773,734,592.13
51210	Өмнөх үеийн үр дүн	833,161,139.69	832,202,182.17
51220	Тайлант үеийн үр дүн	-	(58,467,590.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	886,912.59	32,724,409.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>907,172,725.28</u></b>	<b><u>880,244,685.94</u></b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>255,364,500.00</b>	<b>311,067,600.76</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,760,000.00</b>	<b>6,660,500.76</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,760,000.00	6,660,500.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
120005	Түрээсийн орлого	5,760,000.00	5,040,000.00
120009	Бусад орлого	-	1,620,500.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>249,604,500.00</b>	<b>304,407,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	249,604,500.00	304,407,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	249,604,500.00	304,407,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>320,774,007.98</b>	<b>369,535,190.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>320,774,007.98</b>	<b>369,166,190.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	317,835,868.77	333,214,955.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,162,649.72	176,395,978.22
210101	Үндсэн цалин	148,204,849.72	126,106,619.98
210102	Нэмэгдэл	20,164,200.00	33,822,258.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,793,600.00	16,467,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,150,326.98	21,338,074.73
210201	Тэтгэврийн даатгал	16,517,960.68	14,265,858.14
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,436,067.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,756,939.13
210204	Ажилгүйдлийн даатгал	-	342,091.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,632,366.30	3,537,118.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,893,770.00	32,820,398.00
210301	Гэрэл, цахилгаан	1,225,700.00	1,297,908.00
210302	Түлш, халаалт	1,000,000.00	2,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	495,000.00	494,700.00
210304	Байрны түрээс	15,173,070.00	28,527,790.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,729,336.14	11,632,175.86
210401	Бичиг хэрэг	2,752,787.00	3,511,296.83
210402	Тээвэр, шатахуун	4,790,337.00	5,068,733.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,973,862.14	3,052,146.03
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,212,350.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,815,452.00	15,819,917.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	29,000.00
210604	Урсгал засвар	12,815,452.00	15,790,917.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,812,200.00	7,294,766.00
210702	Дотоод албан томилолт	5,812,200.00	7,294,766.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,717,190.00	6,253,150.00



Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,412,230.00	3,522,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,410.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	199,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,100.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,000.00	122,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,550.00	10,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,554,943.93</b>	<b>61,660,496.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	35,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,554,943.93	61,625,496.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,938,139.21</b>	<b>35,951,234.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,698,128.00</b>	<b>25,734,278.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,698,128.00	24,238,701.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,495,577.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,240,011.21</b>	<b>10,216,956.97</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,240,011.21	10,216,956.97
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>369,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>369,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	369,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(65,409,507.98)</u></b>	<b><u>(58,467,590.04)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>69,328,625.24</b>
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	69,328,625.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(69,328,625.24)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(65,409,507.98)</u></b>	<b><u>(127,796,215.28)</u></b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>256,105,023.60</u></b>	<b><u>311,186,301.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,500,523.60</b>	<b>6,779,201.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,500,523.60	6,779,201.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	5,760,000.00	5,040,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,760,000.00	5,040,000.00
120009	Бусад орлого	740,523.60	1,739,201.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>249,604,500.00</b>	<b>304,407,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	249,604,500.00	304,407,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	249,604,500.00	304,407,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>256,752,982.60</u></b>	<b><u>311,196,302.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>256,752,982.60</b>	<b>311,196,302.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>248,114,843.39</b>	<b>275,245,067.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	176,330,123.46	176,522,195.00
210101	Үндсэн цалин	143,372,323.46	143,550,195.00
210102	Нэмэгдэл	20,164,200.00	20,164,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,793,600.00	12,807,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,396,292.19	21,182,936.00
210201	Тэтгэврийн даатгал	12,343,095.03	14,683,354.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,763,299.29	1,480,277.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,410,639.43	1,435,146.89
210204	Ажилгүйдлийн даатгал	352,659.86	322,020.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,526,598.58	3,262,135.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,326,210.00	33,924,688.00
210301	Гэрэл, цахилгаан	1,225,700.00	1,297,908.00
210302	Түлш, халаалт	1,000,000.00	2,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	495,000.00	494,700.00
210304	Байрны түрээс	13,605,510.00	29,632,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,170,605.74	11,163,836.03
210401	Бичиг хэрэг	3,431,120.00	3,424,640.00
210402	Тээвэр, шатахуун	4,960,900.00	4,960,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,778,585.74	2,778,596.03
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,287,452.00	15,121,246.00
210604	Урсгал засвар	13,287,452.00	15,121,246.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,812,200.00	7,294,766.00
210702	Дотоод албан томилолт	5,812,200.00	7,294,766.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,791,960.00	10,035,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,875,500.00	3,466,900.00

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,410.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	199,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,100.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,336,500.00	3,960,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,550.00	10,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,638,139.21</b>	<b>35,951,234.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,398,128.00</b>	<b>25,734,278.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,698,128.00	24,238,701.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,700,000.00	1,495,577.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,240,011.21</b>	<b>10,216,956.97</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,240,011.21	10,216,956.97
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(647,959.00)</u></b>	<b><u>(10,001.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(647,959.00)</b>	<b>(10,001.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>672,900.00</b>	<b>24,941.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>24,941.00</b>	<b>14,940.00</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>886,912.59</b>	<b>898,570,647.63</b>	970,321,043.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>886,912.59</b>	<b>898,570,647.63</b>	970,321,043.22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			(65,409,507.94)	(65,409,507.94)
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>886,912.59</b>	<b>833,161,139.69</b>	904,911,535.28
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>886,912.59</b>	<b>833,161,139.69</b>	904,911,535.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(958,957.52)	(958,957.52)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>886,912.59</b>	<b>832,202,182.17</b>	903,952,577.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		101,166,121.93		101,166,121.93
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,766,200.00			1,766,200.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			(127,796,215.28)	(127,796,215.28)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,863,483.00</b>	<b>102,053,034.52</b>	<b>704,405,966.89</b>	877,322,484.41

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	304,407,100.00	300,969,344.03	3,437,755.97	99%
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	304,407,100.00	300,969,344.03	3,437,755.97	99%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	275,795,500.00	275,245,067.03	550,432.97	100%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	176,525,200.00	176,522,195.00	3,005.00	100%
Үндсэн цалин	143,553,200.00	143,550,195.00	3,005.00	100%
Нэмэгдэл	20,164,200.00	20,164,200.00	-	100%
Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	12,807,800.00	-	100%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,183,000.00	21,182,936.00	64.00	100%
Тэтгэврийн даатгал	14,122,000.00	14,683,354.60	(561,354.60)	104%
Тэтгэмжийн даатгал	1,765,200.00	1,480,277.89	284,922.11	84%
ҮОМШӨ-ний даатгал	1,412,200.00	1,435,146.89	(22,946.89)	102%
Ажилгүйдлийн даатгал	353,100.00	322,020.74	31,079.26	91%
Эрүүл мэндийн даатгал	3,530,500.00	3,262,135.88	268,364.12	92%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,166,100.00	33,924,688.00	241,412.00	99%
Гэрэл, цахилгаан	1,298,000.00	1,297,908.00	92.00	100%
Түлш, халаалт	2,500,000.00	2,500,000.00	-	100%
Цэвэр, бохир ус	495,000.00	494,700.00	300.00	100%
Байрны түрээс	29,873,100.00	29,632,080.00	241,020.00	99%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,170,900.00	11,163,836.03	7,063.97	100%
Бичиг хэрэг	3,431,700.00	3,424,640.00	7,060.00	100%
Тээвэр, шатахуун	4,960,600.00	4,960,600.00	-	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,778,600.00	2,778,596.03	3.97	100%
<b>Нормативт зардал</b>	-	-	-	-
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,122,500.00	15,121,246.00	1,254.00	100%
Урсгал засвар	15,122,500.00	15,121,246.00	1,254.00	100%
<b>Томилолт, зочны зардал</b>	7,514,200.00	7,294,766.00	219,434.00	97%
Дотоод албан томилолт	7,514,200.00	7,294,766.00	219,434.00	97%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,113,600.00	10,035,400.00	78,200.00	99%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,467,000.00	3,466,900.00	100.00	100%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100%
Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00	-	100%

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	199,900.00	88,100.00	69%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	-	100%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,960,000.00	3,960,000.00	-	100%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,000.00	(10,000.00)	0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	28,611,600.00	25,734,278.00	2,877,322.00	90%
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	0%
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,611,600.00	25,734,278.00	2,877,322.00	90%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,111,600.00	24,238,701.00	2,872,899.00	89%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,495,577.00	4,423.00	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	304,407,100.00	300,969,344.03	3,437,755.97	99%
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	304,407,100.00	294,190,143.03	10,216,956.97	97%
Улсын төсвөөс санхүүжих	304,407,100.00	294,190,143.03	10,216,956.97	97%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	6,779,201.00	(6,779,201.00)	0%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,040,000.00	(5,040,000.00)	0%
Бусад орлого	-	1,739,201.00	(1,739,201.00)	
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	0%
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	0%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			-	0%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>			-	0%
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			-	0%
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	0%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23.00	20.00	3.00	87%
Удирдах ажилтан	4.00	4.00	-	0%
Гүйцэтгэх ажилтан	16.00	13.00	3.00	86%
Гэрээт ажилтан	3.00	3.00		

Цагааннуур чөлөөт бүсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	2019.02.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:		Цагааннуур чөлөөт бүс		Мянган төгрөгөөр
				САГ-2019/306/СТА-ТШЗ

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Тайлант хугацаанд нийт 5 хувь хүнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан 11,030.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон. Тус чөлөөт бүс нь 23 орон тооны ажилтан ажиллуулахаар батлуулсан боловч гүйцэтгэлээр 17 орон тооны ажилтан ажиллаж, үйл ажиллагаа явуулаагүй тул ажлын ачаалал бага байхад гэрээт ажилтанд ажлын хөлс олгосон.	11,030.0	Зөвлөмж өгөх	Захирагч Нягтлан бодогч	А. Аманкелди М.Аманкелди
Тайлант оны эцэст 2 харилцагчтай холбоотой насжилт өндөртэй 1,156.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1,156.0	Албан шаардлага өгөх		
Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 833.1 м <sup>2</sup> газрыг 1,666.2 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан байна. Гэтэл Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар захирамж болон газрын кадастрын зургаар 883.1 м <sup>2</sup> талбайг эзэмшүүлэхээр шийдвэр гарсан байна.		Албан шаардлага өгөх		
Тус чөлөөт бүс нь 2006 онд үүсгэн байгуулагдсан, 2015 оноос 2018 он хүртэлх 4 жилийн хугацаанд 1,031,620.0 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт хүлээн авсан боловч үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байна.		Албан шаардлага өгөх		
<b>Дүн</b>	<b>12,186.0</b>			

